

## Хүний хөгжлийн санхүүжилт

**Д. Цэрэнпил**

**МУИС-ийн Эдийн Засгийн Дээд**

**Сургуулийн багш, доктор, профессор**

Хүний хөгжил нь өнөөдөр онол, практикийн ихээхэн боловсруулалт шаардсан олон талтай, төвөгтэй асуудал болж байна. Үүний дотор хүний хөгжлийн санхүүжүүлэлтийн асуудал нь улс орны эдийн засгийн хөгжлийн түвшин, нөхцөлтэй харилцан нягт уялдаатай тавигдана.

Монгол улсад хүний хөгжлийн асуудал, түүний санхүүжилт ямар байгааг судалж, энэ үндсэн дээр боловсруулсан цуврал материалыг эрхэм уншигч та бүхэнд зориуллаа.

### 1. Өмнөх ба өнөөгийн байдал

Хүний хөгжил нь эдийн засгийн өсөлт, санхүүгийн хөрөнгийн чадвартай холбоотой. Хүний хөгжил энэ бол зорилго, эдийн засгийн өсөлт. Санхүүжилт бол хэрэгсэл. Ийнхүү эдийн засаг, санхүүжүүлэх хөрөнгийн өсөлт нь хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, хүний чадавхийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Хүний хөгжил, эдийн засаг, санхүүгийн өсөлтийн хооронд зүгээр ердийн холбоо биш, энэ нь хүмүүнлэг нийгмийн зайлшгүй захиалга юм.

Монголд нүүдлийн уламжлалт соёл иргэншлийн зэрэгцээ суурин соёл иргэншлийн шинэ хэвшил бүрдэж бий болсон нь хүний хөгжлийн талаар чухал нөлөөтэй таатай нөхцөл боллоо. Монголын хүн ам хэдийгээр тооны хувьд цөөн боловч харьцангуй түргэн өсөлттэй, ихээхэн залуужсан бүтэцтэй, өргөн уудам нутагтаа таруу, сийрэг байршилтай, нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон өвөрмөц онцлогтой. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хүн ам зүйн нөлөөлөл ихтэй байдаг. Монголын эдийн засаг жижиг, өсөлтийн хурд удаан, тэгээд ч бүтцийн хувьд зохисжиж чадаагүй, дотоодын санхүү, хуримтлалын нөөцийн хэмжээ, чадал нэн хомс учир хүн амын орлого туйлын бага, ерөнхийдөө ядуу буурай хөгжилтэй орон юм.

Монгол 70 гаруй жилд эдийн засаг, нийгмийн янз бүрийн үе шат, уналт, сэргэлтийн нугачааг туулахдаа хүний хөгжил, хүн амын аж амьдралыг дээшлүүлэх асуудлыг төр засаг анхааралдаа байлгаж байгаа бодит боломж, нөхцөлтэйгээ уялдуулан шийдвэрлэж ирсэн. Сүүлийн жилүүдээс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих, өргөн ардчилалын шинэ үе эхэлсэн. Үүний улмаас Монголын хүн амын хөгжил, түүний санхүүжилтын асуудлыг 1991 оныг хүртэлх, 1991 оноос хойшхи гэж хоёр үе болгон авч үзэх нь зүйтэй юм.



## 1991 оноос өмнөх үеийн хүний хөгжил, санхүүжилт

1921 оны Ардын хувьсгалын ялалтаас хойш 70 жилийн түүхэн хугацаанд шинэ эдийн засаг, аж ахуйн байгуулалтыг цогцлон бүрдүүлэх явцад хүн амаа эрүүлжүүлэн, эрүүл мэндийг хамгаалах, боловсрол олгох, шинжлэх ухааны тогтолцоог бий болгож хөгжүүлж, чамлалтгүй амжилтад хүрсэн. Мөн зохих бэлтгэл бүхий үндэсний боловсон хүчний нөөц чадавхийг бүрдүүлж чадсан юм. Энэ хугацаанд хүн амын тоо 3 дахин өсч, чанарын шинэ түвшинд хүрсэн. Хүн ам бүтцийн хувьд залуужиж, Монгол улс хүүхэд, залуучуудын орон болсон. Нийт хүн амын 70 гаруй хувийг хүүхэд, залуучууд эзэлж байна.

Ардын боловсролыг буй болгон хөгжүүлж, бүх ард иргэдээ бичиг үсэгтэй болгож, сургуулийн насны бүх хүүхдэд бүрэн бус дунд суурь боловсрол эзэмшүүллээ. Насанд хүрсэн 5 хүн тутмын нэг нь дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой болсон юм.

1960-аад оноос аж үйлдвэрлэлт, эдийн засгийн гол салбруудыг эрчимтэй хөгжүүлэх зорилт тавигдаж, мэргэжилтэй ажилчид, инженер те хнийн ажилтныг бэлтгэх шаардлага өндөржлөө. Үүнтэй уялдаж аж үйлдвэр, хөдөө аж ахуй, барилга, үйлчилгээний салбрын мэргэжилтэй ажилчдыг сургаж бэлтгэх чиглэлтэй Техник Мэргэжлийн Сургуулийг төрөлжүүлэн олноор байгуулж, олон мянган залуучуудад мэргэжил эзэмшүүлэх сургалтын далайцтай ажил явагдаж эхэлсэн. Мөн гадаад, дотоодын их дээд сургуульд төрөл бүрийн инженер, техникчдыг бэлтгэх зорилгоор олон зуун залуучуудыг суралцуулсан юм. Энэ нь ажиллагсдын мэргэжлийн түвшинг өндөржүүлэх, хүний чадавхийн хөгжилд мэдэгдэхүйц шинэ дэвшил болсон. Мэргэжлийн сургалтанд үйлдвэрлэл ба төсвийн хөрөнгөөс гарах санхүүжилт эрс нэмэгдсэн. Монголд ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалтын уялдаа холбоо бүхий тогтолцоо бүрэлдсэн.

Хүн ардад эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар өргөн арга хэмжээ авсан. Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын системийг бий болгосон.

Өндөр настан, тахир дутуу, тэжээгчээ алдсан хүмүүсийг байнгын тэтгэвэртэй болгож хөдөлмөрийн чадвараа түр алдагсад, хүүхэд төрүүлэх, асрамжлахад эхчүүдэд тэтгэмж өгөх, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд зориулалтын тэтгэмж жил бүр олгох, өнчин, ядуу хүмүүст халамж үзүүлэх зэрэг арга хэмжээний санхүүжилтэд нийгмийн даатгалын сан, улсын төсвөөс ихээхэн хөрөнгө зориулах болсон.

Эдийн засаг болон хүний хөгжлийн талаар нилээд амжилтад хүрч, эдгээр нь хоорондоо харилцан нягт холбоо, нөлөөлөл бүхий хүчин зүйл болж чадсан. Эдийн засгийн өсөлт дээр суурилож хүмүүнлэг хөгжил явагдаж ирсэн. Төрийн ниймийн бодлогоор тавьсан зорилгыг хэрэгжүүлэх ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэх боломжийг өргөтгөх нөхцлийг аажмаар бүрдүүлж байлаа. Үүнийг үйлдвэрлэсэн үндэсний орлогын өсөлт, салбарын бүтцийн өөрчлөлтөөс үзэж болно.



| Хүснэгт 1. |                      |                                   |      |                  |                  |         |        |        |                     |       |
|------------|----------------------|-----------------------------------|------|------------------|------------------|---------|--------|--------|---------------------|-------|
| Он         | Бүгд<br>(сая<br>төг) | Өмнөх<br>үеэс<br>өсөлтийн<br>хурд | Бүгд | Салбарын бүтэц % |                  |         |        |        |                     |       |
|            |                      |                                   |      | Аж<br>үйлдвэр    | Хөдөө<br>аж ахуй | Барилга | Тээвэр | Холбоо | Худалдаа<br>хангамж | Бусад |
| 1940       | 638.8                | 100                               | 100  | 8.5              | 61.0             | 0.8     | 0.6    | 0.1    | 9.1                 | 20.0  |
| 1950       | 879.3                | 137.6                             | 100  | 9.8              | 59.4             | 1.3     | 5.9    | 0.6    | 11.0                | 12.0  |
| 1960       | 1892.2               | 215.2                             | 100  | 14.6             | 22.8             | 6.7     | 8.9    | 0.2    | 44.2                | 2.5   |
| 1970       | 3135.2               | 165.7                             | 100  | 22.6             | 25.3             | 5.8     | 6.8    | 0.6    | 36.2                | 2.3   |
| 1980       | 5576.9               | 177.9                             | 100  | 29.3             | 15.0             | 6.1     | 10.1   | 1.1    | 36.3                | 2.0   |
| 1989       | 8646.0               | 155.0                             | 100  | 33.8             | 19.9             | 7.1     | 9.0    | 1.5    | 26.9                | 1.8   |
| 1990       | 8327.5               | 96.3                              | 100  | 35.0             | 20.3             | 5.6     | 8.5    | 1.7    | 27.4                | 1.7   |

Үндэсний орлогын өсөлт, салбарын бүтцийн хувьсгал нь тус улсын эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлтийг харуулахын зэрэгцээ хүн амын аж байдал, соёлын түвшинг дээшлүүлэхэд аятай нөхцөл бий болгож байлаа. 1990 оныг 1980 онтой зэрэгцүүлэхэд Монголын хүн амын тоо 1,3 дахин, дотоодын нийт бүтээгдэхүүн 1,7 дахин, нэг хүнд ногдох хэмжээ нь 1,3 дахин өслөө. Харин цаашдаа эдийн засгийн хямрал улам гүнзгийрч 1990 оноос өсөлт нь буурсан.

| Хүснэгт 2. Дотоодын нийт бүтээгдэхүүн (1993 оны зэрэгцүүлэх үнээр, млрд. төг) |       |        |        |
|-------------------------------------------------------------------------------|-------|--------|--------|
|                                                                               | 1980  | 1989   | 1990   |
| Дотоодын нийт бүтээгдэхүүн                                                    | 124.1 | 214.0  | 208.7  |
| Нэг хүнд ногдох нь төгрөгөөр                                                  | 77139 | 106022 | 100530 |

Монгол улсад хүн амд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, иргэд өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүүхэд төрүүлэх, асарч хүмүүжүүлэх зэрэгт шаардлагатай зардал, дэмжлэг, туслалцааг үзүүлэх бүх зардлыг төр засаг хариуцаж улсын ба орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байлаа. Энэ нь Монгол улсын төсвийн орлого, зарлагын өсөлт, бүтэцтэй холбоотой.

| Хүснэгт 3. Монгол улсын нэгдсэн төсөв (оны үнээр, сая төг)                                                                          |        |            |        |            |        |            |        |            |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|------------|--------|------------|--------|------------|--------|------------|
|                                                                                                                                     | 1975   |            | 1980   |            | 1989   |            | 1990   |            |
|                                                                                                                                     | Дүн    | Бүтэц<br>% | Дүн    | Бүтэц<br>% | Дүн    | Бүтэц<br>% | Дүн    | Бүтэц<br>% |
| Орлого-бүгд                                                                                                                         | 2455.6 | 100        | 3451.4 | 100        | 5243.3 | 100        | 5328.7 | 100        |
| Шууд татвар                                                                                                                         | 964.5  | 39.3       | 1250.4 | 36.2       | 2551.3 | 48.7       | 2339.2 | 43.9       |
| Шууд бус татвар                                                                                                                     | 1307.8 | 53.3       | 1913.5 | 55.4       | 2265.2 | 43.2       | 2080.9 | 39.1       |
| татварын бус орлого                                                                                                                 | 183.3  | 7.4        | 287.5  | 8.4        | 426.8  | 8.1        | 908.6  | 17.0       |
| Зарлага-бүгд                                                                                                                        | 2633.1 | 100        | 3939.8 | 100        | 7062.3 | 100        | 6812.3 | 100        |
| а                                                                                                                                   | 940.9  | 35.7       | 1421.0 | 36.1       | 3224.8 | 45.7       | 2921.5 | 42.9       |
| б                                                                                                                                   | 1640.9 | 62.3       | 2462.2 | 62.4       | 3718.9 | 52.7       | 3748.5 | 55.4       |
| в                                                                                                                                   | 1089.7 | 41.4       | 1608.1 | 40.8       | 2780.8 | 39.4       | 2956.7 | 43.4       |
| а – Материалаг салбарын санхүүжилт<br>б – Үйлдвэрлэлийн бус салбарын зардал<br>в – Үүнээс нийгмийн үйлчилгээний салбарын санхүүжилт |        |            |        |            |        |            |        |            |



Энэ хугацаанд улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2,2 дахин, зарлага 2,9 дахин өсчээ. Материаллаг салбарын санхүүжилт 3,1 дахин, нийгэм соёлын арга хэмжээ, үйлчилгээний салбарын санхүүжилт 2,7 дахин нэмэгдлээ. Тухайн үед төсвийн зарлагын 40,8-аас 43,4 хувийг боловсрол, эрүүлийн хамгаалах, шинжлэх ухаан, соёл болон нийгэм хангамжийн бусад үйлчилгээнд зориулж байлаа. Эдгээр санхүүжилт нь чухамдаа хүний чадавхийн хөгжилд чиглэгдэж байсан юм.

Аймаг, хот, бүс нутагт хүн амын эрүүл мэнд, боловсрол соёлын хөгжлийн асуудлыг зохион байгуулах, түүний мөнгөн хөрөнгийн хангамжийг бүрдүүлэхэд орон нутгийн төсөв чухал рольтой. Дээрхи хугацаанд орон нутгийн төсвийн нийт орлого 3,1 дахин, зарлага 2,9 дахин өсч, улсын төвлөрсөн төсвөөс нийт зарлагын 24-45 хувьтай тэнцэх хэмжээгээр жил бүр татаас олгож байлаа. Төсвийн санхүүжилтийн зэрэгцээ хүн амын нийгмийн хөгжлийн хэрэгцээнд үйлдвэр, аж ахуйн газруудын нийгмийн хөгжлийн фондоос нилээд хөрөнгө зарцуулдаг байсан. Төвлөрсөн төлөвлөгөөт аж ахуйг хөтөлж байсан нөхцөлд макро эдийн засгийн түвшинд балансжилт, тэнцвэр төдийлөн хангагдаагүй, төсөв, төлбөрийн баланс удаан хугацаанд алдагдалтай, санхүүгийн дотоод нөөц хомс байсан нь хүний хөгжлийн санхүүжилтийг хангахад нилээд төвөгтэй байлаа. Энэ нөхцөлд үйлдвэр, аж ахуйн газрын ашиг, хуримтлалын дийлэнх хэсгийг төсөвт төвлөрүүлж, бүх нөөцийг болон цалин хөлсийг дэрээс хатуу тогтоосон нормативаар тэгшитгэн хувиаралдаг тогтолцоотой байв. Үүний нөгөө талаар хүн амын нийгмийн хамгааллыг төр дангаараа хариуцдаг, хуучин тогтолцоо нь ядмаг эдийн засгийг улам хүндрүүлсэн төдийгүй хувь хүний өөрийнхөө төлөө хүлээх хариуцлагыг сулруулж, бүхнийг төрд даатгасан идэвхгүй бэлэнчлэх байдлыг бий болгосныг тэмдэглэх ёстой.

Монгол хүний хөгжлийг санхүүжүүлэхэд бэрхшээл хязгаарлалт их байлаа. Монгол улсын төсөв 1960-аад оноос эхлэн алдагдалтай болсон.

| Хүснэгт 4. Алдагдал         |       |       |        |        |
|-----------------------------|-------|-------|--------|--------|
|                             | 1975  | 1980  | 1989   | 1990   |
| Алдагдал-Дүн (сая төг)      | 177.5 | 488.4 | 1819.0 | 1483.6 |
| Үндэсний орлогод эзлэх хувь | 3.9   | 8.7   | 21.0   | 17.8   |
| Төсвийн зарлагад эзлэх хувь | 6.7   | 12.4  | 25.8   | 21.8   |

Төсвийн алдагдал жилээс жилд өсөж 1990 онд 1975 оныхоос 8,3 дахин өслөө. Үүний зэрэгцээ уг алдагдлын үндэсний орлого, төсвийн зарлагад эзлэх хувийн жин өсөж 1990 онд харьцангуйгаар 17,8 хувь ба 21,8 хувьд хүрчээ. Энэ нь улсын санхүүгийн дотоод чадвар дорой байгааг харуулна. Төсвийн алдагдлыг гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр нөхдөг байжээ. Хүний хөгжлийн санхүүжилтийг хангах нэг гол нөхцөл нь улсын төлбөрийн балансын чадвар байх ёстой. Монгол улсын төлбөрийн баланс мөн алдагдалтай байлаа.



| Хүснэгт 5. Төлбөрийн баланс (оны үнээр сая ам. доллар) |        |        |        |
|--------------------------------------------------------|--------|--------|--------|
|                                                        | 1980   | 1989   | 1990   |
| Экспорт                                                | 402.8  | 721.5  | 660.7  |
| Импорт                                                 | 547.8  | 963.0  | 924.0  |
| Алдагдал                                               | -145.0 | -241.5 | -263.3 |
| Экспортод алдагдалын эзлэх хувь                        | 36     | 33.5   | 39.9   |

Төсөв, төлбөрийн баланс хоёулаа алдагдалтай байгаа нь хүний хөгжлийг санхүүжүүлэх боломж ихээхэн хязгаарлагдмал байсныг харуулна.

Дүгнэлт: Хэдийгээр эдийн засгийн өсөлт удаан, дотоодын санхүүгийн нөөц чадвар хязгаарлагдмал, төсөв, төлбөрийн баланс алдагдалтай байсан боловч хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бүх нийтийг бичиг үсэгтэн болгох, суурь боловсрол мэргэжил эзэмшүүлэх асуудалд Монгол улсын төр засаг байнга анхаарч боломжийнхоо хирээр зохих хэмжээний санхүүжүүлэлтээр хангаж, бодит байдлаар хүний чадавхийн хөгжилд нилээд амжилтад хүрч чадсан юм.

### Шилжилтийн үеийн хүний хөгжлийн санхүүжилт

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих өөрчлөлт шинэчлэлийг 1991 оноос эхэлснээс хойш 6 жилийн хугацаа өнгөрч байна.

Өөрчлөлт, шинэчлэлийн эхэн үед дотоод, гадаад олон хүчин зүйлээс шалтгаалан эдийн засгийн хямрал гүнзгийрч, ард түмний амьдралын түвшин огцом буурч улс орны амьдрал нэн эгзэгтэй заагт тулж ирсэн.

- Эдийн засаг түргэсэх хурдацтайгаар унаж, нэг хүнд ногдох үндэсний орлогын хэмжээ арваад жилийн өмнөх түвшинд хүртэл буурсан. ДНБ-ний үйлдвэрлэл жил дутам 6 орчим хувиар буурч байв.
- Санхүү, мөнгөний тогтолцоо гүнзгий хямарч, мөнгөний ханш унаж, үнэ, тариф огцом нэмэгдэж, инфляци өндөр түвшинд хүрсэн.
- Улсын санхүү, валютын нөөц шавхагдаж, төсвийн болон төлбөрийн тэнцлийн байдал ноцтой хүндэрч дотоод, гадаад өр, хүү, торгууль өсөн нэмэгдэж байлаа.
- Хүн амын хүнсний болон бусад нэн чухал шаардлагатай бүтээгдэхүүний хүрэлцээ хангамж багасч, бараа материалын улсын нөөц барагдсан байлаа.
- Ажилгүйдэл, ядуурал газар авч нийгмийн хурц асуудал болов. Ард иргэдийн амьжиргааны түвшин 40 гаруй хувиар буурсан байна.
- Боловсрол, эрүүлийн хамгаалах, соёлын салбарт хямрал гүнзгийрч өмнө олсон амжилтаас ихээхэн ухрав.
- Нийгмийн хэв журмын зөрчил, гэмт хэрэг нэмэгдэж ард иргэдийн амгалан тайван аж төрөх баталгаа алдагдах байдал бий болов.



Төр засгаас нийгмийн харилцааг ужиг гажуудлаас гаргах улс оронд бий болсон хүнд байдлыг гэтлэн давах шинэчлэл өөрчлөлтийг эрчимтэй үргэлжлүүлж цаашдын жам ёсны хөгжлийн үндсийг тавих нэн хариуцлагатай зорилт тавин ажиллаж байна. Шилжилтийн үеийн эдийн засгийн өөрчлөлт нь хүний хөгжлийн байдалд нэгэн адил төвөгтэй байдлыг бий болгов. Иймээс энэ үеийн эдийн засаг, санхүүгийн өөрчлөлтийн үр дүнг тусгайлан авч үзэх нь зүйтэй юм.

Нийгмийн байгуулал, улс төрийн тогтолцоог өөрчлөх, эдийн засагт дангаар ноёрхож байсан төрийн өмчийг хувьчлах, хувийн хэвшлийг бий болгон хөгжүүлэх, үнэ тариф, валютын ханшийг чөлөөлөх, гадаад худалдааг либералчлах, зах зээлийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг бодлогын чанартай цогцолбор арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Шилжилтийн энэ хугацааг хоёр үндсэн үе шатад хувааж үзэж болно.

#### Нэгдүгээр шат (1991–1992 он)

Хямрал хурцадсан, үнийн огцом өсөлт, өндөр инфляци, үйлдвэрлэлийн хурдан уналт, төлбөрийн чадварын доройтол, төсөв болон гадаад худалдааны тэнцлийн ноцтой хүндрэл, гадаад өрийн өсөлт, валютын ба бараа таваарын уналт, улсын нөөцийн шавхагдал, хүн амын хүнсний ба нэн чухал шаардлагатай бүтээгдэхүүний хомсдол, ажилгүйдэл, ядуурал зэрэг нь нийгмийн хурц асуудал болов. Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1991 онд 9.2, 1992 онд 9.5 хувиар тус тус багассан. Хугацаа хэтэрсэн гадаад өр төлбөр 115 сая доллар болов. Инфляцийн түвшин 325 хувьд хүрч, манай улс дэлхийн хамгийн өндөр инфляцитай арван орны нэг болсон байв.

#### Хоёрдугаар шат (1993–1996 он)

Тогтворжилт эхлэх алхам. Энэ хугацаанд үнэ, валютын дотоодод хөрвөх ханш, гадаад худалдааг чөлөөлөх, өмч хувьчлал, санхүү, мөнгө зээлийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх гол ажил хийгдлээ. Санхүү, мөнгө зээлийн хүрээнд хатуу бодлого явуулж шинэчлэл хийгдэж нааштай үр дүнд хүрч эхлэв. Гадаад валют, бараа таваарын улсын нөөцийг сэргээж, татвар, нийгмийн даатгал, хангамж, халамжийн тогтолцоог бүрдүүлэх, цалин тэтгэвэрийг нэмэгдүүлэх, банкны зээлийн хүүг бууруулав. Өмчийн олон хэлбэр, аж ахуйн шинэ хэвشلүүд бий болж, үйлдвэр аж ахуйн нэгжүүд зах зээлийн эдийн засгийн нөхцөлд зохицон ажиллаж хуримтлалаа бүрдүүлэх нааштай үр дүн эхлэв. Зах зээлийн үр ашигтай секторын хөгжлийг илүү дэмжих, эдийн засгийн бүтцийг өөрчлөх, дэд бүтцийн сазбарыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын чанартай арга хэмжээнүүдийг тууштай хэрэгжүүлж ирсний үр дүнд макро эдийн засагт тогтворжилтын хандлага бий боллоо.



| Хүснэгт 6. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд |        |        |        |        |        |        |
|---------------------------------------------|--------|--------|--------|--------|--------|--------|
|                                             | 1990   | 1991   | 1992   | 1993   | 1994   | 1995   |
| Хүн амын тоо (оны эцэст мян. хүн)           | 2149.3 | 2187.2 | 2215.0 | 2250.0 | 2280.0 | 2317.0 |
| ДНБ-өсөлт (%)                               | -2.5   | -9.2   | -9.5   | -3.0   | 2.3    | 6.3    |
| Үүнээс: -аж үйлдвэр                         | -0.3   | -13.1  | -11.5  | -10.6  | 2.7    | 20.7   |
| -хөдөө аж ахуйд                             | -2.0   | -5.1   | -4.0   | -7.1   | 7.1    | 5.0    |
| Инфляци (%)                                 | -      | 52.7   | 325.5  | 183.0  | 66.3   | 53.1   |
| Ажилгүйчүүдийн тоо (мян. хүн)               | -      | 55.4   | 54.0   | 71.9   | 74.9   | 45.1   |
| Экспорт (сая ам. доллар)                    | 660.7  | 348.0  | 388.4  | 382.6  | 367.5  | 511.6  |
| Импорт (сая ам. доллар)                     | 924.0  | 360.9  | 418.3  | 379.0  | 258.4  | 388.7  |

Дотоодын нийт бүтээгдэхүүний уналтын хурдац 1993 онд өмнөх хоёр жилийнхээс 3 дахин саарч, 1994 оноос 2.3 хувь өсч, 1995 онд 6.3 хувиар нэмэгдэв. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ аж үйлдвэрт 20.7 хувь, хөдөө аж ахуйд 5.0 хувь өслөө. Инфляцийн сарын дундаж түвшин 1992 онд 12.2 хувь, 1993 онд 9.1 хувь, 1994 онд 4.3 хувь, 1995 онд 3.6 хувь болж буурлаа. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн хоёр жилд ашигтай гарах боллоо. Сүүлийн гурван жил дараалан урсгал төсөв ашигтай болж харин нэгдсэн төсвийн алдагдал 1995 онд ДНБ-ний 2.9 хувьтай тэнцэж байна.

Монгол орны эдийн засгийн гол салбарууд- хөдөө аж ахуй, аж үйлдвэрт өмнөх онуудтай харьцуулахад илүү ахиц гарч байгаа нь эдийн засгийн өсөлтөд түлхэц болж буй гол хүчин зүйл болж байна. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр нь энэ оны байдлаар манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг, нэмэгдэл өртгийн 70 гаруй хувийг хангаж байна. 1995 оны эцэст нийт малын тоо бүх төрөл дээр 28.6 сая (хонин толгойд шилжүүлснээр 66 сая) толгойд хүрсэн. 1995 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 87 хувь нь үйлдвэрлэлийн хүрээнд, 11.5 хувь нь үйлчилгээний хүрээнд бий болсон байна. Ийнхүү эдийн засагт гарч байгаа нааштай өөрчлөлт нь Монголын ард түмний аж амьдралын түвшинд эерэг нөлөөлж, хүний чадавхийг хөгжүүлэх суурь үндэс болж байна.

Хүний чадавхийн хөгжил, түүний санхүүжилт нь шилжилтийн үеийн үнэ, мөнгө, санхүүгийн бодлогын хэрэгжилттэй шууд холбоотой.

### Үнэ ханш

Жолоодлоггүй инфляцийн аюулаас сэргийлэх зорилгоор үнэ, тарифыг чөлөөт тогтолцоонд шилжүүлэх, бүтээгдэхүүн, бараа материалын хангамжийг сайжруулах, санхүү, мөнгө, зээлийн хатуу бодлого явуулсны үр дүнд инфляцийн өсөлт жил дараалан буурч, үнэ ханшийн байдал нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, цаг хугацааны хүчин зүйлтэй уялдан явагдах нөхцөл бүрдэв. Үндэсний валют-төгрөг дотооддоо чөлөөтэй хөрвөдөг боллоо.